# МОНГОЛ УЛС
# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар А/161 Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2.1, Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын Бүх Ард Түмний спортын XV наадмын зардалд 50.000.000 (тавин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай

2.Зарцуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

4.Монголын Бүх Ард Түмний спортын XV наадамд баг тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулахыг Зохион байгуулах комисс (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

231010444

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 25 өдрийн
А/161 захирамжийн хавсралт

МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XY НААДАМ,
ХЭНТИЙ АЙМГААС ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН
ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

| № | Спортын төрөл | Зардлын нэр | Санхүүжилтийн дүн, хуваарь | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3 дугаар сар | 4 дүгээр сар | 5 дугаар сар |
| 01 | Монголын Бүх Ард Түмний Спортын XV наадам | Тамирчдын спортын нэмэлт, бэлтгэлийн зардал (10 спортын төрлөөр 64 тамирчин хамрагдана) | 20740000 | | |
| | | Бүсийн тэмцээний болон тамирчдын спортын нэмэлт зардал | | 9098000 | |
| | | Шигшээ тэмцээний зардал (20 спортын төрлөөр 163 тамирчин, 24 дасгалжуулагч, 8 албаны төлөөлөгч нийт 195 хүн хамрагдана) | | | 20162000 |
| Бүгд | | | 20740000 | 9098000 | 30162000 |
| НИЙТ ДҮН | | | | | 50000000 |